



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/384

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 13 дугаар багт Инженерийн шугам сүлжээ бүхий гэр хороолол төслийн хүрээнд хийгдсэн Гадна дулаан, цэвэр усны шугам сүлжээний ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Т.Бат-Эрдэнэ

(Барилгын хөгжлийн төвийн ББЗХХ-ийн хяналтын инженер)

Х.Даваасүрэн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Д.Идэрмөнх

(Мөрөн сумын Засаг дарга)

Ч.Цэрэнсүрэн

(Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний улсын хяналтын байцаагч)

Ж.Жавзанпагма

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Ж.Нацагдорж

(Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

Ш.Нямханд

(“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн ерөнхий инженер)

Г.Даваадорж

(“Хөвсгөл Эрчим хүч”ХХК-ийн ерөнхий инженер)

С.Ариунаа (Мөрөн сумын 13-р багийн Засаг дарнга)

Зохиогч байгууллагын төлөөлөл:
Ж.Ганболд ("Монкузбасс" ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Б.Гантулга ("Энерготех сервис" ХХК-ийн Ерөнхий инженер)

А.Алтангэрэл ("Энерготех сервис" ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:
Д.Сүхээ (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)
У.Ариунаа (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн инженер)

Н.Дэлгэрмөрөн (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн инженер)

Ц.Бэхбаяр (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Комиссын нарийн бичгийн дарга:
Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилгын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН